

**ЦАГ УУР, ОРЧНЫ ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ**

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл: Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон: Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Төрийн албаны тухай хууль, 2017 оны 12 дугаар сарын 07 –ны өдөр Дагаж мөрдөх огноо: 2019 оны 2 дугаар улирлаас	
<u>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:</u>	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын Хоёрдугаар хавсралтаар (2019-01-11-ны өдөр)
<u>Байгууллагын нэр: Ус цаг уур, орчны шинжилгээний төв</u>	<u>Нэгжийн нэр: Цаг уур, орчны технологийн хэлтэс</u>
<u>Албан тушаалын нэр: Цаг уур, орчны технологийн хэлтсийн дарга</u>	<u>Албан тушаалын ангилал, зэрэглэл: Төрийн үйлчилгээ, ТҮ-10</u>
<u>Ажлын цаг: өдрийн /8 цаг/</u>	<u>Ажлын байрны албан ёсны байршил: Ховд аймаг Жаргалант сум Буюнт баг УЦУОШТөв</u>
<u>Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн</u>	<u>Онцгой нөхцөл: Хэт халуун, хүйтэн, байгаль цаг агаарын хүнд нөхцөл, илүү цагаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай байх</u>

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ
Албан тушаалын зорилго: 1.Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөрт ажлыг зохион байгуулж, хэмжлийн нэгдмэл байдлыг ханган, технологийг мөрдүүлж, салбар, нэгжийг өдөр тутмын арга зүйн удирдлагаар хангах. Байгууллагын дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээг зохион байгуулах 2. Улсын сүлжээний хөдөө аж ахуйн цаг уур, цөлжилтийн шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөрийн хэргжилтийг зохион байгуулж, салбар, нэгжийн тасралтгүй, хэвийн ажиллагаа, арга зүйн удирдлагыг хангах. А. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, салбар, нэгжид технологи, стандартыг мөрдүүлэх, техник, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, хяналт тавьж, хангах. Б. Сар бүрийн тайлан, хэмжлийн үр дүнд техник, шүүмж шалгалт хийж, алдаагүй архив, мэдээллийн сан бүрдүүлнэ. В. Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын салбарт уур амьсгалын үйлчилгээ үзүүлнэ. Г. Мэргэшлийн чиглэлээр өөрийгөө болон салбар, нэгжийн ажиллагсадыг чадавхжуулах, орлон, хөрвөн ажиллах. Ур чадвартай байх. 3. Судалгааны ажил хийх, хөдөө аж ахуйн цаг уурын горим, нөөцийг тогтоох.
Албан тушаалын зорилт: 1. Цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж, салбар, нэгжийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах 2. Цаг уур, орчны шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник, технологи, арга зүйн шинэчлэлийг нэвтрүүлэх, хяналт тавих, хөгжүүлэх, улам боловсронгуй болгох 3. Ажиглалт, хэмжлийн технологийн мөрдөлтөд хяналт тавих, алдаа, зөрчил, үл тохирлыг арилгах, шалган туслах, мэргэжлийн арга зүйгээр хангах, техник, шүүмж шалгалт хийх, алдаагүй архив, мэдээллийн сан бүрдүүлэх 4. Уур амьсгалын үйлчилгээг Дэлхийн цаг уурын байгууллагын тогтоосон тэргүүлэх 5 чиглэлээр үзүүлэх 5. Мэргэжлийн боловсон хүчний сургалт, мэргэшлийн зэрэг, ур чадварыг дээшлүүлэх 6. Цаг уур, орчны технологийн хэлтсийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах 7. Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын ажлыг зохион байгуулах, мэдээ тайланг хугацаанд хүргэх 8. Улсын сүлжээний хөдөө аж ахуйн цаг уурын шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөрийн хэргжилтийг зохион байгуулж, салбар, нэгжийн тасралтгүй, хэвийн ажиллагаа, арга зүйн удирдлагыг хангах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр
1 дүгээр зорилтын хүрээнд:	1. Салбаруудын хөтөлбөрийн биелэлтийг сар, улирал болгон дүгнэх, тасралтгүй байдлыг хангах - Цаг уурын шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөр - Хөдөө аж ахуйн цаг уурын шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөр - Гадаргын ус судлалын шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөр - Мөстөл, цэвдэг судлалын шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөр - Орчны хяналт шинжил-гээний шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөр - Мэдээллийн сангийн хөтөлбөрийн биелэлт, сан бүрдүүлэлт - Цаг уур, орчны шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник, технологи, арга зүйн шинэчлэлийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, улам боловсронгуй болгох талд хяналт тавьж ажиллах 2. Улирлын чанартай ажил, цаг үеийн ажил, жил, улирлын хөтөлбөрийн биелэлтийг хангах, урьдчилсан бэлтгэлийг хянаж, зохион байгуулах. 3. Амралт, өвчтэй, чөлөөтэй, сургалт, семинарын үеийн тасралтгүй ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, зохицуулах. 4. Харуулуудын орлон ажиглагч нарын сургалт, бэлэн байдалд хяналт тавих 5. Гэнэтийн саатал, тасалдлыг шуурхай арилгах, зохицуулах.	1. Хөтөлбөрүүдийг бүрэн биелүүлсэн байна. 2. Салбар, нэгжийн ажилд тасалдал гараагүй байх 3. Саатал, гэмтлийг даруй арилгасан байх.	Хянах-Х Хариуцан гүйцэтгэх-Г
2 дугаар зорилтын хүрээнд:	1. Улсын сүлжээний хөдөө аж ахуй цаг уурын шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний дараах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах. - Бэлчээрийн ургамлын үзэгдэл зүйн хашаалсан талбайн ажиглалтын хөтөлбөр - Бэлчээрийн ургамлын үзэгдэл зүйн хашаалаагүй талбайн ажиглалтын хөтөлбөр - Таримлын ургамлын ургах орчны ажиглалтын хөтөлбөр - Хөрсний чийгийн ажиглалтын хөтөлбөр - Бэлчээрийн төлөв байдлын ажиглалт /Зуны явуул судалгаа/, Өвлийн бэлчээрийн ажиглалт /өвлийн явуул судалгаа/л - Бэлчээрийн зонхилох хөнөөлт шавьж, мэрэгчдийн ажиглалтын хөтөлбөр	1.Хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлсэн байх. х/б 100% 2.Салбар, нэгжийн ажилд тасалдал гараагүй байх 3.Саатал, гэмтлийг даруй арилгасан байна 4.Хөтөлбөрт ажлын тасралтгүй байдал хангагдана	Хариуцан гүйцэтгэх-Г

	2. Бүх чиглэлийн мэдээлэл, үйлчилгээний ажлын хөтөлбөрүүд - ХААЦУ-ын тойм мэдээ - ХААЦУ-ын зөвлөмж - ХААЦУ-ын урьдчилсан мэдээгээр үйлчлэх - Цаг үеийн нэмэлт, тусгай ажиглалт, судалгааны хөтөлбөрүүд 3. Салбар, нэгжид гар дамжуулан шалгах, техник, шүүмж шалгалтыг хийж хэвшүүлэх. 4. Техник, шүүмж шалгалтыг арга зүй, технологи, онолын түвшинд хийх 5. Сар бүрийн техник, шүүмж шалгалтын дүн, хариу зааварчилгааг хэлтэст хэлэлцүүлж, алдаа зөрчлийг арилгах, хяналт тавих, давтагдахаас сэргийлэх ажил зохиох 6. Мэдээллийн санг бүрдүүлж, цахим болон цаасан тайланг хугацаанд нь хүлээлгэн өгөх	5.ХААЦУ-ын чиглэлийн мэдээ мэдээллээр ард иргэдэд үйлчлэх 6.Ажиглалтын чанар 100% -руу тэмүүлэх. 7. Цаасан ба цахим тайлан алдаагүй байх 8. Архив, мэдээллийн санг алдаагүй бүрдүүлэх	Туслах-Т
3 дугаар зорилтын хүрээнд:	1. Салбаруудын сар бүрийн техник, шүүмж шалгалтаар илэрсэн үл тохирол /хэмжил, арга зүй, технологи/-ыг шүүн хэлэлцэж, арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулах. 2. Салбаруудад төлөвлөгөөт болон цаг үеийн шалган туслах ажлыг хийж, үл тохирлыг арилгах, тэргүүн туршлага, ололтыг нэвтрүүлэх ажлыг хийх. 3. Салбаруудын сар бүрийн техник, шүүмж шалгалтын явц, хариу зааварчилгыг хэрэгжүүлэх, алдаа, зөрчлийг шуурхай арилгаж буй эсэхэд хяналт тавьж ажиллах. 4. Салбарын сарын тайлан, мэдээллийн сангийн бүрдлийг сонсож, хяналт тавих.	1. Ажиглалт, хэмжил, боловсруулалт, архив бүрдэл, шүүмж шалгалтын технологийн алдаа багасаж, арилах 2.Технологи, хэмжлийн үл тохирлыг бүрэн арилгах. 3. Нэгдсэн хариу зааварчилга, зөвлөмж, шийдвэр гаргах 4. Сар бүр мэдээллийн сан бүрдүүлсэн байх	Хариуцан гүйцэтгэх-Г
4 дугаар зорилтын хүрээнд:	1. Жил бүр УЦУОШТ-ийн сургалт, семинар, мэргэжлийн хичээлийн нэгдсэн төлөвлөгөө, график гаргаж баталгаажуулан мөрдөх, өртөө, харуулд зайны сургалт явуулах. 2. Ажлын байрны сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, боловсруулах, баталгаажуулж мөрдөх, шинээр ажилд орж буй хүмүүсийг дадлагажуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах. 3. Мэргэшлийн зэрэг, ур чадварыг сайжруулах, давтан сургалтыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж, хяналт тавьж ажиллах. 4. Инженер, техникч нарын орлон, хөрвөн ажиллах бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах.	Албан хаагчдын мэргэжлийн ур чадвар сайжирсан байна. Хөтөлбөрт ажлын тасралтгүй байдал, боловсон хүчний нөөц бүрдэнэ.	Хариуцан гүйцэтгэх-Г
5 дугаар зорилтын хүрээнд:	1. Жил, хагас жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь тайлагнах. 2. Төв, орон нутгийн салбаруудын	1. Салбар бүрийг удирдлагаар хангаж ажиллана. Салбарын дотоод ажил	Хариуцан гүйцэтгэх-Г

	тасралтгүй ажиллагаанд хяналт тавьж, сар, улирлаар ажлыг нь дүгнэж, зөвлөлд асуудал, санал оруулж шийдвэрлүүлэх. 3. Цаг уур, орчны технологийн хэлтсийн албан хэрэг, архивыг бүрдүүлж ажиллах. 4. Хууль, эрх зүйн баримт бичиг, дээд байгууллагын шийдвэр, удирдлагын үүрэг даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулах. 5. Салбар, нэгжийн шинжилгээний ажлыг дүгнэх. 6. Хэлтсийн инженер, техникч нарыг төрийн албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах, судалгаа хийх чиглэлээр дэс дараатай сургаж бэлтгэх, орлох, хөрвөх чадвар эзэмшүүлэх	тасралтгүй байдал хангагдана. 2. Орлох, хөрвөх чадвартай, мэргэжлийн өндөр түвшний инженер, техникчтэй болно.	
6 дугаар зорилтын хүрээнд:	Засгийн газрын 89-р тогтоолын дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах 2. Монгол улсын болон Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын захирамж, албан даалгавар, ИТХ-ын тогтоол, албан тоотын хариу, үндэсний хөтөлбөрүүдийн биелэлт гэх мэт байгууллагад мөрдөгдөх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтандаа авч хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах 3. Байгууллагын хэмжээнд дотоод аудит хийх, төлөвлөгөө боловсруулж, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан, дүгнэлт, зөвлөмж сайжруулалтын ажлыг хийх.	Мэдээ, тайлан хугацаандаа гарч, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн, салбарын хэвийн үйл ажиллагаа хангагдана.	Хариуцан гүйцэтгэх-Г
7 дугаар зорилтын хүрээнд:	1. Албан хэрэг хөтлөлтийн арга зүйн баримт бичиг, зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдүүлэх 2. Шинжилгээний материалын баримтыг архивын заавар, журамд нийцүүлэн зохих бүрдлийн дагуу хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгүүлэн өгөх 3. Салбаруудын мэдээллийн дэд санг үүсгэх, баяжуулах ажлыг зохион байгуулах, цаасан болон цахим санг АМДС-д өгөх	Албан хэрэг хөтлөлт стандартын шаардлагын дагуу хийгдэх, бүрэн бүрдэлтэй баримтыг архивт шилжүүлэх	Хариуцан гүйцэтгэх-Г
8 дугаар зорилтын хүрээнд:	1 Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих, сургалт зохион байгуулах ажлыг зохион байгуулах -Төвийн нийт ажиллагсдын ТАХ-ийн баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах -Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалт зохион байгуулах -ТАХ-ийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухайн иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хүлээн авч	ТАХ-ийн баримтлах ёс зүйн зөрчилөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчил гаргасн иргэнд тусламж үзүүлэх, өргөдөл гомдолыг үнэн зөв шийдвэрлэх	Хариуцан гүйцэтгэх-Г

	холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх		
Бусад зорилтын хүрээнд:	1. Дээд байгууллага, удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж тайлагнах, байгууллагын хэмжээнд зохиогдож буй ажилд идэвхтэй оролцох 2. Мэдлэг боловсорлоо байнга дээшлүүлж, шинээр нэвтэрч байгаа технологи, программ хангамжинд суралцах, уур амьсгалын чиглэлээр судалгааны ажлын үр дүнг боловсруулах хяналт тавих 3. Мэргэшил мэдлэгээ дээшлүүлэх, сургалт семинарт тогтмол хамрагдах 4. Төрийн албаны хууль, эрх зүйн орчинтой холбоотой заалтуудыг мөрдөж ажиллах	Ажлын хариуцлага, хувь хүний хөгжил, сайжирсан байх	Хариуцан гүйцэтгэх-Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Дээд боловсролын бакалавр түүнээс дээш магистр /доктор/
Мэргэжил	Цаг уур инженер
Мэргэшил	Цаг уур , Ус судлал, Орчны чиглэлээр мэргэшсэн
Туршлага	УЦУОХШ-ний аль нэг салбарт 5-аас доошгүй жил тогтвортой ажилласан байх
Ур чадвар	1. Багаар ажиллах 2. Харилцааны соёл 3. Манлайлал 4. Шинэ техник, технологи эзэмшсэн байх 5. Англи болон бусад хэлээр уншиж сонсож ойлгодог 6. Компьютер, интернет, сүлжээний орчинд ажиллах 7. Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандарт эзэмшсэн байх 8. Асуудал дэвшүүлэх, шийдвэрлэх

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: 1. Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Салбар хариуцсан ерөнхий технологич инженерүүд - 5 2. Ахлах техникч -4 3.Өртөөний дарга – 9 4. Өртөөний техникч -36 5. Цаг уурын харуулын техникч - 7 6. БОШЛабораторийн эрхлэгч – 1 7. БОШЛабораторийн инженер – 1 8. БОШЛабораторийн техникч – 2 9. Ус судлалын харуулын ажиглагч -11 10.Мөстөл судлалын техникч-1 Нийт - 77	Бусад харилцах субъект: <i>Байгууллагын дотор:</i> - Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга - Синоптик инженерүүд - ЗСААХ-ийн дарга - Нярав, жолооч - Архив бичиг хэргийн эрхлэгч - Судлаач инженер - Бусад албан хаагчид <i>Шууд харилцах байгууллага:</i> - Цаг уур, орчны шинжилгээний газар - Газрын харъяа мэргэжлийн байгууллагууд /УЦУОСМХ-ийн хэлтэс нэгж, Төрийн архив мэдээллийн сангийн хэлтэс, НЦУТ, БОШТЛ/ <i>Шууд бус харилцах байгууллага:</i> Ус цаг уур, орчны шинжилгээний мэдээллийг хэрэглэгч төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЦУОШТөвийн ЦУОТехнологийн хэлтсийн дарга /Ц.Дэлгэр/ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2025 оны 01 дугаар сарын 02-ны өдөр	Байгууллагын нэр: УЦУ ОШТ/ОБ Шийдвэрийн огноо: 2019.11.15 Дугаар: А/31

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: УЦУ ОШТ/ОБ	
Шийдвэрийн огноо: 2025.01.02	
Дугаар:	
(тамга/тэмдэг) (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2025 оны 01 дугаар сарын 02 өдөр	 (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЦАГ УУРЫН АХЛАХ ТЕХНИКЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл: Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон: Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Төрийн албаны тухай хууль, 2017 оны 12 дугаар сарын 07 – ны өдөр Дагаж мөрдөх огноо: 2019 оны Хоёрдугаар улирлаас	
<u>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:</u>	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын Хоёрдугаар хавсралтаар (2019-01-11-ны өдөр)
<u>Байгууллагын нэр:</u> Ус цаг уур, орчны шинжилгээний төв	<u>Нэгжийн нэр:</u> Цаг уур, орчны технологийн хэлтэс
<u>Албан тушаалын нэр:</u> Хөдөө аж ахуйн цаг уурын ахлах техникч	<u>Албан тушаалын ангилал, зэрэглэл:</u> Төрийн үйлчилгээ, ТҮ-7
Ажлын цаг: 8 цаг өдрийн	<u>Ажлын байрны албан ёсны байршил:</u> Ховд аймаг Жаргалант сум Буянт баг УЦУОШТ
Хөдөлмөрийн нөхцөл: Ажлын хэвийн нөхцөл, шаардлагатай үед орон нутагт ажиллана.	Онцгой нөхцөл: Байгаль цаг агаарын хүнд нөхцөл, илүү цагаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай байх

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ	
Албан тушаалын зорилго: Улсын сүлжээний хөдөө аж ахуй цаг уурын шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт, ХАА-н цаг уурын хэмжлийн үр дүн, хэмжлийн технологи, стандартад нийцэж буйг хянаж, энгийн үл тохиролыг илрүүлэн арилгах, хэмжлийн үр дүн, тайланд техник шалгалт хийж, алдаагүй архив, мэдээллийн сан бүрдүүлэх, салбар нэгжид заавар зөвлөмж өгөх, салбаруудын шуурхай мэдээний үнэн зөвд тогтмол хяналт хийж, цаг хугацаандаа дамжигдаж байгааг хянах, хөдөө аж ахуй цаг уурын түүвэр судалгааг үнэн зөв гаргах, тойм мэдээ мэдээллээр үйлчлэх.	
Албан тушаалын зорилт: 1. Хөтөлбөрийн дагуу хийсэн ажиглалт, хэмжилтийг тогтоосон хугацаанд нь бүрэн хийсэн эсэхийг шалгаж холбогдох арга хэмжээг авч ажиллана. 2. Салбаруудын шинжилгээний хөтөлбөрийн дагуу хийсэн хэмжлийн үр дүнд дэлгэрэнгүй техникч шалгалт хийж, цахим сан үүсгэж, хариу зааварчилгаа зөвлөмжийг бичиж, хугацаанд нь инженерт гаргаж өгөх. 3. Цаг уур, ХАА-н цаг уурын шинжилгээний ажилд техник шалгалт хийх чадвартай байх ба ажлын хүрээндээ ашиглагдах программыг бүрэн эзэмшиж ажиллаж чаддаг байх. 4. Өөрийн мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлэх, салбар нэгжид шинээр ажилд орж буй хүмүүст өөрийн чиглэлийн мэдлэгийг батлагдсан хөтөлбөрийн дагуу конспект бэлтгэж хичээл зааж дадлагажуулах. 5. ХАА-н цаг уурын бүх төрлийн мэдээг шалгж хянах, түүвэр судалгаа хийж, тойм бичиж цахим хуудсанд тавих, цахим хуудасны мэдээг байнга шинэчилж баяжуулж ажиллах 6. Салбарын инженер байхгүй тохиолдолд тус салбарын ажлыг хариуцан ажиллаж, хөдөө орон нутгийн салбар нэгжид алган туслах ажлаар явж ХАА-н цаг уурын хөтөлбөрт ажлыг шалгаж акт бичиж хугацаатай үүрэг, заавар зөвлөмж өгч ажиллана.	

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр	1. Хөтөлбөрийн дагуу хийсэн ажиглалт,	1. Хөтөлбөрийг бүрэн	Хариуцан

зорилтын хүрээнд	хэмжилтийг тогтоосон хугацаанд нь бүрэн хийсэн эсэхийг шалгаж холбогдох арга хэмжээг авч ажиллана. Хадлан, бэлчээрийн хашаалсан талбайн ажиглалтын хөтөлбөр - Хадлан, бэлчээрийн хашаалаагүй талбайн ажиглалтын хөтөлбөр - Таримлын ажиглалтын хөтөлбөр - Хөрсний чийгийн ажиглалтын хөтөлбөр - Зун, өвлийн хээрийн судалгаа, бэлчээрийн даац багтаамж тодорхойлох ажил - Бэлчээр, хадлангийн өвчин, хортон, мэрэгчдийн ажиглалтын хөтөлбөр - Бүх чиглэлийн мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөрүүд - Цаг үеийн нэмэлт, тусгай ажиглалт, судалгааны хөтөлбөрүүд 2. Салбар, нэгжийн хөтөлбөрийн хэрэгжилтэд бүрэн хийгдсэнд байнга хяналт тавьж, сар бүр мэдээлж байх. 3. Улирлын чанартай ажил, цаг үеийн ажил, жил, улирлын хөтөлбөрийн биелэлтийг хангах, урьдчилсан бэлтгэлийг хянаж, хэрэгцээт хэмжих хэрэгсэл, сэлбэг, дэвтэр, хүснэгт, бусад зарцуулалтыг зохион байгуулах	хэрэгжүүлсэн байх. 2. Салбар, нэгжийн ажиглалт тасалдал гараагүй байх 3. Саатал, гэмтлийг даруй арилгасан байна 4. Хөтөлбөрт ажлын тасралтгүй байдал хангагдах	Гүйцэтгэх-Г Хянах-Х Туслах-Т
2 дугаар зорилтын хүрээнд	Салбаруудын шинжилгээний хөтөлбөрийн дагуу хийсэн хэмжлийн үр дүнд дэлгэрэнгүй техникч шалгалт хийж, цахим сан үүсгэж, хариу зааварчилгаа зөвлөмжийг бичиж, хугацаанд нь инженерт гаргаж өгөх. 1. ХААЦУ-ын бүх чиглэлийн хөтөлбөрт ажил хөтөлбөрийн дагуу хийгдэж байгаад хяналт тавих. 2. Салбар, нэгжээс ирж байгаа сар бүрийн тайлан материалд дэлгэрэнгүй техник шалгалт хийж, сан үүсгэж, зааварчилгаа, зөвлөмж бичиж инженерт хүлээлгэн өгөх. 3. Хөтөлбөрт ажлаа тасалдуулж, буруу хийж байгаа салбаруудтай тусгай ажил зохиож, тус ажлын чанар дээшлүүлэх тал дээр санаачлага гаргаж ажиллах	1. Хэмжих хэрэгсэл, хэмжпийн технологи ижил, стандартын, гэрчилгээжсэн, баталгаажсан байх. 2. Арга зүй, технологи улам боловсронгуй болох 3. Хэмжих хэрэгсэл, хэмжлийн технологид шинэчлэлт хийгдсэн, нэвтэрсэн, эзэмшсэн байх.	Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х
3 дугаар зорилтын хүрээнд	Цаг уур, ХАА-н цаг уурын шижилгээний ажилд техник шалгалт хийх чадвартай байх ба ажлын хүрээндээ ашиглагдах программыг бүрэн эзэмшиж ажиллаж чаддаг байх. 1. Өөрийн ажилд ашигладаг Word, Exel, Access зэрэг програм дээр чөлөөтэй ажиллаж чаддаг байх	1. Ажилд хэрэглэгддэг Word, Exel, Access программ дээр ажилладаг байх	Хариуцан гүйцэтгэх-Г
4 дүгээр зорилтын хүрээнд	Өөрийн мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлэх, салбар нэгжид шинээр ажилд орж буй хүмүүст өөрийн чиглэлийн мэдлэгийг батлагдсан хөтөлбөрийн дагуу конспект бэлтгэж хичээл зааж дадлагажуулах. - ХАА-н цаг уурын ажилд техник шалгалт хийх чадвартай байх ба программыг бүрэн эзэмшиж ажиллаж чаддаг байх	1. Арга зүйгээр ханган ажиллаж, заавар зөвлөмжөөр үйлчилж ажиллана. 2. Уур амьсгалын үйлчилгээ тогтмолжсон байх 3.	Хариуцан гүйцэтгэх-Г

	-Өөрийн хариуцсан тоног төхөөрөмж /компьютер/-н хэвийн ажиллагааг хангаж ажиллана. -Монгол улсын стандарт MNS2608-1976"-ийн 1,1-д Аравтын бутархай тооны бүхэл ба бутархай хэсгийг ялгах тэмдэг нь таслал гэсэн заалтыг баримталсан эсэх -Ховд аймагт ургадаг ургамлын аймгийн судалгаа хийж грибар үзүүлэн таниулах материал гарын авлагатай болж техник болон шүүмж, сургалт, шалгалтанд ашиглана		
5 дугаар зорилтын хүрээнд	ХАА-н цаг уурын бүх төрлийн мэдээг шалгаж хянах, түүвэр судалгаа хийж, тойм бичиж цахим хуудсанд тавих, цахим хуудасны мэдээг байнга шинэчилж баяжуулж ажиллах. -Салбараас гаргаж үйлчилдэг мэдээ мэдээллийн түүвэр судалгааг үнэн зөв хийх 2. Шинээр ажилд орж буй хүмүүсийг дадлаажуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах 1. Ажиллагсадын давтан сургалт, зэрэг дэв, ур чадварыг сайжруулах сургалтыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж, хяналт тавьж ажиллах. 2. Өөрийгөө болон салбарын инженер, техникч нарын орлон, хөрвөн ажиллах, ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, дадлагыг зохион байгуулах.	1.Бүх төрлийн мэдээ мэдээллээр үйлчилж, мэдээний баяжилт хийж ажиллах. 2. Шинээр орж байгаа ажиллагсдад сургалт зохион байгуулж,мэдлэг боловсрол эзэмшүүлэх 3. Бусад салбар нэгжид хөрвөн ажиллах, чадвартай байх.	Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х
6 дугаар зорилтын хүрээнд:	Салбарын инженер байхгүй тохиолдолд тус салбарын ажлыг хариуцан ажиллаж, хөдөө орон нутгийн салбар нэгжид шалган туслах ажлаар явж ХАА-н цаг уурын хөтөлбөрт ажлыг шалгаж акт бичиж хугацаатай үүрэг, заавар зөвлөмж өгч ажиллана. 1.Салбарын инженер амарсан болон шалтгаантай тохиолдолд салбарын ажлыг хариуцан ажиллана. 2.Орон нутгийн салбар нэгжид шалган зөвлөх ажлаар ажиллах чадвар эзэмшсэн байх.	1. Салбарын инженер байхгүй тохиолдолд инженерийн ажлыг орлон хийх чадвартай байх	Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х
Бусад зорилтын хүрээнд:	1.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, байгууллагын хэмжээнд зохиогдож буй ажилд идэвхтэй оролцох 2.Мэдлэг боловсорлоо байнга дээшлүүлж, шинээр нэвтэрч байгаа технологи, программ хангамжинд суралцах, уур амьсгалын чиглэлийн түүвэр судалгааг үнэн зөв гаргаж, үр дүнг боловсруулах 3.Бусад салбаруудтай хамтран ажиллах 3.Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг мөрдөж ажиллах	Ажлын хариуцлага, хувь хүний хөгжил, сайжирсан байх	Хариуцан гүйцэтгэх-Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр түүнээс дээш
Мэргэжил	Хөдөө аж ахуйн цаг уурын инженер
Мэргэшил	Цаг уур, хөдөө аж ахуйн цаг уурын чиглэлээр мэргэжлээ дээшлүүлсэн

Туршлага	Ажиглалт, хэмжлийн технологи эзэмшсэн байх
Ур чадвар	1. Багаар ажиллах 2. Харилцааны соёл 3. Эерэг хандлагатай 4. Манлайлал 5. Шинэ техник, технологи эзэмшсэн байх 6. Компьютер, интернет, сүлжээний орчинд ажиллах 7. Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандарт эзэмшсэн байх 8. Асуудал дэвшүүлэх

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

1. Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
2. Цаг уур, орчны технологийн хэлтсийн дарга
3. МҮХэлтэс болон ЗСААХ-ийн дарга нар

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

1. өртөөний дарга - 9
2. өртөө, харуулын техникч нар - 43

Бусад харилцах субъект:

Байгууллагын дотор:

- ЦУОТХ-ийн салбар хариуцсан инженерүүд,
- Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга
- Синоптик инженерүүд
- ЗСААХ-ийн дарга
- Нярав, жолооч
- Архив бичиг хэргийн ажилтан
- АМДС-ийн инженер
- Бусад албан хаагчид

Шууд харилцах байгууллага:

- Газрын харъяа мэргэжлийн байгууллагууд /УЦУОСМХ-ийн ХААЦУСХ-ийн дарга, аймаг хариуцсан инженер болон бусад инженерүүд/
- *Шууд бус харилцах байгууллага:*

1. Орон нутгийн удирдлага, байгууллага, иргэд
2. Хэвлэл,мэдээллийн байгууллагууд
3. Онцгой тохиолдолд бусад субъект

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЦУОШТөвийн ЦУОТехнологийн хэлтсийн дарга /Ц.Дэлгэр/ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2025 оны 01 дугаар сарын 02-ны өдөр	Байгууллагын нэр: УЦУ ОЦШТ/66 Шийдвэрийн огноо: 2019.11.15 Дугаар: А/31

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: УЦУ ОЦШТ/66	
Шийдвэрийн огноо: 2025.01.02	
Дугаар:	
(тамга/тэмдэг) (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2025 оны 01 дугаар сарын 02 өдөр	 (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2025 оны 01 дугаар сарын 02 өдөр

**УУР АМЬСГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ ТЕХНИКЧИЙН
АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ**

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл: Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон: Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Төрийн албаны тухай хууль, 2017 оны 12 дугаар сарын 07 – ны өдөр Дагаж мөрдөх огноо: 2019 оны Хоёрдугаар улирлаас	
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын Хоёрдугаар хавсралтаар (2019-01-11-ны өдөр)
Байгууллагын нэр: Ус цаг уур, орчны шинжилгээний төв	Нэгжийн нэр: Цаг уур, орчны технологийн хэлтэс
Албан тушаалын нэр: Уур амьсгалын үйлчилгээ харицсан ахлах техникч	Албан тушаалын ангилал, зэрэглэл: Төрийн үйлчилгээ, ТҮМ-5
Ажлын цаг: 8 цаг өдрийн	Ажлын байрны албан ёсны байршил: Ховд аймаг Жаргалант сум Буянт баг УЦУОШТ
Хөдөлмөрийн нөхцөл: Ажлын хэвийн нөхцөл, орон нутагт ажиллана.	Онцгой нөхцөл: Байгаль цаг агаарын хүнд нөхцөл, илүү цагаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай байх

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ
Албан тушаалын зорилго: Цаг уурын шинжилгээний ажлын материалд техник шалгалт хийж дүгнэлт өгч, зөвлөмж бичиж хүргүүлэн арга зүйн удирдлагаар хангах, мэдээллийн сан бүрдүүлэхэд оршино. Олон жилийн түүвэр судалгаа, инженерийн шаардсан судалгааг бүрэн хийж ажиллах. Чанарын дотоод хяналтаас өгсөн чиг үүргийн дагуу сарын мэдээг тулган шалгах
Албан тушаалын зорилт: - Хөтөлбөрийн дагуу хийсэн ажиглалт, хэмжилтийг тогтоосон хугацаанд хийсэн эсэхийг шалгаж хариу зааварчлага цахим хэлбэрээр бичиж алдааны судалгааг инженерт хүлээлгэн өгсөн байна. - Хариуцсан салбарын шинжилгээний ажилд гарч буй адлаа дутагдлын талаар салбар хариуцсан инженерт хүлээлгэн өгсөн байна. - Техник шалгалтын явцад ажиглалтын дэвтэр хүснэгтийн хөтлөлт, ажиглалтын байдал, багаж тоног төхөөрөмжийн байрлалд хийсэн үйлчилгээг нарийвчлан шалгаж 2сар дараалан дахин алдаа давтагдвал санлыг холбогдох хүмүүст тавьж арга хэмжээ авах. - Шаардлагатай нөхцөлд хариуцсан салбарт утсаар ярьж, тухайн шаардлагатай мэргэжлийн хичээл зааварчилгааг хүргүүлж ажиллана. - Шаардлагатай нөхцөлд салбарын инженерийг орлон ажиллах. - Автомат станцын мэдээллийг бүрэн шалгаж сурсан байна. - Салбарын хариуцсан инженер өвчтэй,чөлөөтэй, амралттай тохиолдолд салбарын ажлыг хариуцан, хөрвөж ажиллаж чадах чадвартай байх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	- Хөтөлбөрийн дагуу хийсэн ажиглалт, хэмжилтийг тогтоосон хугацаанд нь бүрэн шалгаж хариу зааварчилгааг цахим хэлбэрээр бичиж алдааны судалгааг инженерт хүлээлгэн өгсөн байна. - Хууль тогтоомж болон харьяалах дээд байгууллага, хүмүүсийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, зохион байгуулах, биелэлтэнд нь хяналт тавих, биелэлтийг нь эргэн тайлагнах - Сар бүр шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын тайлан жилийн эцэст архивын стандартын дагуу үдэж дугаарлан	- Ажлын үүрэг хариуцлага бүтээмж 100% болох. - Ажлын чанар сайжирна хувийн зохион байгуулалт эмх цэгц бүрдэх - Архив, мэдээллийн санг алдаагүй бүрдүүлэх - Салбарын ажилд ахиц гарна. - Ажлын чанар	Хариуцан Гүйцэтгэх-Г Хянах-Х Туслах-Т

	мэдээллийн санд хүлээлгэн өгөх 4. Инженерт шаардлагатай түүвэр судалгааг бүрэн хийж өгөх 5. Хариуцсан салбарынхаа шинжилгээний ажлын талаар судалгааг байнга хөтлөж явна .	дээшлэх улмаар олон жилийн судалгаатай болох	
2 дугаар зорилтын хүрээнд	1. Шинжилгээний ажиглалтын материалд анхан шатны шалгалт боловсруулалт хийх, тайлан материалыг цэвэр нямбай хугацаанд нь чанартай хийх, ажиглалтын технологийн горимыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах 2. Шалгалтын явцад ажиглалтын дэвтэр хүснэгтийн хөтлөлт, ажиглалтын байдал, багаж тоног төхөөрөмжийн байрлалт хийсэн үйлчилгээг нарийвчлан шалгаж илрүүлэн алдаа олон дахин давтагдвал холбогдох хүмүүст мэдэгдэж арга хэмжээ тооцоход санал оруулах 3. Өөрийн мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлэх, шинээр ажилд орж буй хүмүүст конспект бэтгэж байгууллагын удирдлагаар батлуулж хичээл зааж дадлагажуулах ба автомат станцын арга ажилгааг бүрэн эзэмшиж анхан шатанд зааварчилгаа өгөх чадвартай байна. 4. Цаг уур, ХАА-н цаг уурын ажилд техник шалгалт хийх чадвартай байх ба программыг бүрэн эзэмшиж ажиллаж чаддаг байх 5. Өөрийн хариуцсан тоног төхөөрөмж компьютерийн хэвийн ажиллагааг ханган ажиллана.	1. Ажиглалтын чанар 100% -руу тэмүүлэх. 2. Бичиг баримтын эмх цэг бий болох, ажлын цаг горим барих технологи мөрдөлт сайжирах 3. Мэргэжилээ дээшлүүлсэнээр албан хаагчдын ур чадвар дээшилсэн байна. 4. Бусад салбарт орлох,хөрвөж ажиллах чадвар эзэмшинэ. 5. Эд хогшилдоо ариг гамтаа байж ажилгааны хэвийн байдлыг ханган ажиллах.	Хариуцан гүйцэтгэх-Г Туслах-Т Хянах-Х
3 дугаар зорилтын хүрээнд	1. Хариуцсан салбарын шинжилгээний ажлын талаар улирал бүр салбарын инженер, хэлтсийн даргад танилцуулна. 2. Салбаруудаас ирсэн тайланг хугацаанд нь техник шалгалт хийж инженерт хүлээлгэн өгөх 3. Шинжилгээний ажил сайжруулахад санаачлагатай бүтээлч ажиллах	1. Салбарын ажлын чанард ахиц гарна. 2. Уур амьсгалын үйлчилгээ тогтмолжсон байх. 3. Өөрийн чадвах нэмэгдэж . Салбарын ажилын чанар сайжирахад түлхэц болно.	Хариуцан гүйцэтгэх-Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Ажиглалтын явцад багаж тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хянаж холбогдох хүмүүст мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авна. 2. Техник шалгалтын чанар дүнгээ байнга ахиулж ажиллах. 3.Хариуцсан салбарын шинжилгээний ажлыг шалгахдаа үнэн зөв зааврын дагуу шалгаж засварлах шаардлагатай элементүүдийг инженерийн зааварчилгаар зөвшилцөж засна.	1. Арга зүй, хөтөлбөр боловсруулсан байна. 2. Чанараа 100%-руу тэмүүлэх. 3.Салбарын ажлын чанарын үзүүлэлт өснө,	Хариуцан гүйцэтгэх-Г Туслах-Т Хянах-Х
Бусад зорилтын хүрээнд:	1. Дээд байгууллага, удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж тайлагнах, байгууллагын хэмжээнд зохиогдож буй ажилд идэвхтэй оролцох 2. Мэдлэг боловсролоо байнга дээшлүүлж, шинээр нэвтэрч байгаа технологи, программ хангамжинд суралцах, Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх 3. Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг мөрдөж ажиллах	Ажлын хариуцлага, хувь хүний хөгжил, сайжирсан байх. 2.Тухайн хүний мэдлэг дээшилж чадвахжихаас гадна орчин үетэйгээ хөл нийлүүлж ажиллах. 3.Хуулийн хүрээнд ажил үүргээ чанартай явуулах.	Хариуцан гүйцэтгэх-Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Бакалавр түүнээс дээш
Мэргэжил	Цаг уурын инженер
Мэргэшил	Цаг уур, Уур амьсгалын чиглэлээр мэргэжлээ дээшлүүлсэн
Туршлага	Ажиглалт, хэмжлийн технологи эзэмшсэн байх
Ур чадвар	1. Багаар ажиллах 2. Харилцааны соёл 3. Эерэг хандлагатай 4. Манлайлал 5. Шинэ техник, технологи эзэмшсэн байх 6. Англи хэлээр уншиж сонсож ойлгодог 7. Компьютер, интернет, сүлжээний орчинд ажиллах 8. Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандарт эзэмшсэн байх 9. Асуудал дэвшүүлэх

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: 1. Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга 2. Цаг уур, орчны технологийн хэлтсийн дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: 1. өртөөний дарга - 9 2. өртөө, харуулын техникч нар - 43	Бусад харилцах субъект: Байгууллагын дотор: • ЦУОТХ-ийн салбар хариуцсан инженерүүд, • Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга • Синоптик инженерүүд • ЗСААХ-ийн дарга • Нярав, жолооч • Архив бичиг хэргийн ажилтан • АМДС-ийн инженер • Бусад албан хаагчид Шууд харилцах байгууллага: • Газрын харъяа мэргэжлийн байгууллагууд /УЦУОСМХ-ийн УАНС-ны хэлтэс, аймаг хариуцсан инженер болон бусад инженерүүд/ Шууд бус харилцах байгууллага: 1. Орон нутгийн удирдлага, байгууллага, иргэд 2. Хэвлэл,мэдээллийн байгууллагууд 3. Онцгой тохиолдолд бусад субъект

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЦУОШТөвийн ЦУОТехнологийн хэлтсийн дарга /Ц.Дэлгэр/ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2025 оны 01 дугаар сарын 02 ны өдөр	Байгууллагын нэр: УЦУОШТ166 Шийдвэрийн огноо: 2019.11.15 Дугаар: А/31

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: УЦУОШТ166	
Шийдвэрийн огноо: 2025.01.02	
Дугаар:	
(тамга/тэмдэг)	
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2025 оны 01 дугаар сарын 02 өдөр	

МӨСТӨЛ СУДЛАЛЫН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл: Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон: Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Төрийн албаны тухай хууль, 2017 оны 12 дугаар сарын 07 – ны өдөр Дагаж мөрдөх огноо: 2019 оны Хоёрдугаар улирлаас	
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын Хоёрдугаар хавсралтаар (2019-01-11-ны өдөр)
Байгууллагын нэр: Ус цаг уур, орчны шинжилгээний төв	Нэгжийн нэр: Цаг уур, орчны технологийн хэлтэс
Албан тушаалын нэр: Мөстөл судлалын ерөнхий инженер	Албан тушаалын ангилал, зэрэглэл: Төрийн үйлчилгээ, ТҮМ-5
Ажлын цаг: 8 цаг өдрийн	Ажлын байрны албан ёсны байршил: Ховд аймаг Жаргалант сум Буянт баг УЦУОШТ
Хөдөлмөрийн нөхцөл: Ажлын хэвийн нөхцөл, орон нутагт ажиллана.	Онцгой нөхцөл: Байгаль цаг агаарын хүнд нөхцөл, илүү цагаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай байх

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ
